# Хүүхдэд зориулсан Библи
## танилцуулж байна



# Есүст учирсан сорилт


**Зохиогч**: Edward Hughes
**Зураглаач**: Byron Unger; Lazarus
**Орчуулсан**: Damdin Horolsuren
**Найруулсан**: M. Maillot; Sarah S.


**Түүх 38/60**


**www.M1914.org**

***Bible for Children,*** *PO Box 3, Winnipeg, MB R3C 2G1 Canada*



**Зөвшөөрөл: Та энэ бүтээлийг хувилах хуулах эрхтэй харин худалдахыг хориглоно.**


Монгол хэл

Mongolian

**Есүсийг баптизм хүртэж байх үед Бурхан тэнгэрээс "Энэ бол миний хайртай хүү. Түүнд миний таалал оршдог" гэв. Бурхны АРИУН СҮНС Есүс дээр тагтаа адил бууv.**



1

**Удалгүй Бурхны Ариун Сүнс Есүсийг зэлүүд газар уруу дагуулав. Есүс ганцаараа байлаа.**



2


Есүс дөчин өдөр мацаг барьжээ.
Энэ нь тэр ямар ч хоол идээгүй
гэсэн үг.  Тэр маш их өлсжээ.
3


Библи дээр зэрлэг амьтад ч тэнд
байсан гэж бичигдсэн байдаг.
4


Муу сүнс болох Сатан Есүсийг
сорихын тулд түүн дээр ирэв.
5


Дээр үед тэр муу сүнс Бурхны
цэцэрлэг Еден цэцэрлэгийг
устгахын тулд Адам Ева хоёрыг
сорьж байсан юм.  Харин
одоо Есүсийг
сорихоор
иржээ.
6


Сатан Бурхны хүү
Есүсийг хүртэл
сорих гэж хичээв.
7


Муу сүнс "Хэрэв чи Бурхны Хүү
мөн юм бол, Энэ чулууг талх болго"
гэв.  Тэр Есүсийг өлсөж байгааг
мэдсэн байжээ.
8


Тэр Бурхны Хүү чулууг талх болгох чадалтай гэдгийг мэдэж байв. Есүс Муу сүнсний үгэнд орсон болов уу?
9
Үгүй ээ! Есүс муу сүнсний хэлснээр хийгээгүй. Харин хариуд нь Бурхны үгээр хариулсан. "Хүн зөвхөн талхаар бус Бурхны амнаас гарах үг бүрээр амьдарна" гэж бичигдсэн байдаг гэв.
АРИУН БИБЛИ
10
Дараа нь Сатан Есүсийг агуу хот Иерусалемын хүмүүс мөргөл өргөдөг ариун сүмийн орой дээр аваачив. Тэгээд Сатан юу гэсэн бол оо?
11
"Хэрэв чи Бурхны Хүү мөн юм бол, доошоо үсэр" гээд Муу сүнс "Түүний үгэнд тэнгэр элч нар ирж чамайг аварна" гэж гардаг биз дээ гэв.
12
"Үгүй!" гэж Есүс хариулав. "Чи өөрийн Бурхан Эзнийг бүү сорь гэж бас байдаг" гэв.
АРИУН БИБЛИ
13
Муу сүнс дахин сорих гэж хичээв. Тэр Есүсийг хотын хамгийн өндөр уулын оргил дээр авч ирэв.
14













Есүст учирсан сорилт

Бурханы үг Библээс авсан түүх

Матай 4, Лук 4

"Таны үгсийн тунхаглал гэгээрүүлдэг."
Дуулал 119:130

Бурхны гэм гэж нэрлэдэг муу зүйлийг бид хийдгийг Бурхан сайн мэднэ. Гэмийн шийтгэл нь үхэл юм.

Бурхан бидэнд маш их хайртай Тэрээр өөрийн хүү Есүсийг бидний гэмийн төлөөс болгон загалмайн үхэлд тушаасан. Есүс дахин амилж мөнхийн улсдаа буцсан! Одоо Бурхан бидний гэмийг уучилж чадна.

Хэрвээ та гэмээсээ эргэхийг хүсвэл, Бурханд хандан ийнхүү хэлээрэй: Бурхан минь ээ, Би Есүс миний төлөө үхээд дахин амилсан гэдэгт итгэж байна. Миний амьдралд орж ирээд миний гэмийг уучлаач тэгээд би шинэ амьдралаар амьдарч дараа нь тантай хамт мөнхөд амьдрах болно. Таны хүүхэд шиг Таны төлөө амьдрахад туслаач.
Амен Иохан 3:16

Библи уншиж өдөр бүр Бурхантай ярилцаарай!